

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, байгууллагын дотоод аудитын 2025 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Санхүү, нийцлийн чиглэлээр

Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу санхүүгийн чиглэлээр 2, нийцлийн чиглэлээр 1, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2, нийт 5 удаагийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилбал:

Д/д	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан зохион байгуулалтын нэгжүүд	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1	2	3	4	5
1.	Санхүү, үйл ажиллагааны чиглэлээр	Хойд бүс дэх газар	1	төлөвлөгөөт, гүйцэтгэлийн
		Өмнөд бүс дэх газар	1	төлөвлөгөөт
2.	Нийцлийн чиглэлээр	Өмнөд бүс дэх газар	1	төлөвлөгөөт
3.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Төв болон орон нутаг дахь нэгжүүд	2	төлөвлөгөөт

Дотоод аудитын хяналт шалгалтыг дэлгэрэнгүйгээр танилцуулбал:

- Хойд бүс дэх газарт өгөгдсөн “Ажлын хариуцлагыг сайжруулах тухай” 2024 оны 03 дугаар албан даалгаврын биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт явуулж, үр дүнг 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01-02/13 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан.

- Байгууллагын даргын 05 дугаар сарын 20-ны өдрийн 01-08/04 дүгээр удирдамжийн дагуу Өмнөд бүс дэх газрын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаа, бусад байгууллагатай байгуулсан гэрээ, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд санхүүгийн болон нийцлийн аудит хийж, үр дүнг 06 дугаар сарын 05-ны өдрийн 01-08/14 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан, зөвлөмжийг 06 дугаар сарын 09-ний өдрийн 08/1130 дугаар албан бичгээр хүргүүллээ.

Хоёр. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төв болон харьяа 7 нэгжид 2 удаагийн удирдамжийн дагуу дотоод аудит хийж, үр дүнг 2 удаагийн илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан, 2 удаагийн зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн 2025 оны 1 дүгээр улирлын зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Байгууллагын нэр	Удирдамж, илтгэх хуудасны огноо, дугаар	Зөвлөмжийн огноо, дугаар	Зөвлөмж биелэлт ирүүлсэн огноо, дугаар	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6
1	Гадаадын иргэн, харьяатын газар	Удирдамжийн огноо, дугаар: 2025.04.08, 01-08/03 Илтгэх хуудасны огноо, дугаар: 2025.04.14, 01-08/13	2025.04.29 08/22	2025.05.22 06/19	100%
2	Агаарын замын боомт хариуцсан газар		2025.04.29 08/819	2025.04.29 11/48	100%
3	Дорноговь аймаг дахь газар			2025.06.16 12/41	70%
4	Хойд бүс дэх газар			2025.05.26 15/50	100%
5	Өмнөд бүс дэх газар			2025.05.23 08-13/52	100%
6	Баруун бүс дэх газар			2025.05.10 14/56	100%
7	Зүүн бүс дэх газар			2025.05.26 08-16/31	100%
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс		-	-	-
Нийт		-	-		95.7%

Гурав. Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аудитын газрыг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан талаар

Хууль зүй, дотоод хэргийн яам болон Үндэсний аудитын газрыг дараах мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2024 оны IV улирлын тайланг 2025 оны 01/83 дугаар, энэ оны I дүгээр улирлын тайланг 01/729 дугаар, II дугаар улирлын тайланг 08/1178 дугаар албан бичгээр;

- Үндэсний аудитын газрын 2024 оны санхүүгийн аудитаар илэрсэн байгууллагад холбогдох зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилтийг 01/1232 дугаар албан бичгээр;

- Эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөний энэ оны хагас жилийн хэрэгжилт 87 хувьтай үнэлэгдэж, эрсдэлийн үнэлгээний тайланг 08/1125 дугаар албан бичгээр хүргүүлж, эрсдэлийн бүртгэлийн мэдээллийг салбарын хяналт-шинжилгээ, эрсдэлийн үнэлгээний цахим сан <https://mojha.unelgee.gov.mn/risk/>-д 06 дугаар сарын 20-ны өдөр оруулан, эрсдэлийг бүртгэн, баталгаажууллаа.

- Байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний санал болон Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тэмдэглэлээр өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/944 дугаар, 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/950 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Дөрөв. Бусад асуудлаар

Байгууллагын хуулийн санд байршуулсан даргын тушаалаар баталсан заавар, дүрэм, журам зэрэг нийт 51 эрх зүйн актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 03 дугаар сарын 25-ны өдрийн 08/09 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан, 03 дугаар сарын 27-ны өдрийн 08/15 дугаар албан бичгээр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалаар сумдын төрийн байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт шалгалт хийх, сургалт зохион байгуулах, зөвлөн туслах ажлын удирдамжийн дагуу 02 дугаар сарын 06-наас 17-ны өдрүүдэд Хэнтий, Дорнод аймгийн 8 сумдад нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн хяналт шалгалтаар ажиллаж, байгууллагын даргад 02 дугаар сарын 20-ны өдрийн 08/05 дугаар илтгэх хуудсаар томилолтоор ажилласан талаар танилцуулсан.

Байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн 04 дүгээр сарын 10-ны өдрийн Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгыг данс бүртгэлд тусгах талаар хэлэлцсэн хуралдаанд, байгууллагын даргын 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан хөрөнгө хүлээн авах ажлын хэсэгт дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн оролцсон.

Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан 8 сургалт, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан 6 удаагийн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт албан хаагчид хамрагдсан.

Хэлтсийн дарга БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА) болон БНСУ-ын Цагаачлалын судалгаа, сургалтын төв (MRTC)-тэй хамтран зохион байгуулсан “Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх” сургалтад 04 дүгээр сарын 14-нөөс 27-ны өдрүүдэд, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс” чуулга уулзалт, арга зүйн сургалтад 05 дугаар сарын 14, 16-ны өдрүүдэд тус тус оролцож сертификат авсан.

Байгууллагын даргын баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын удирдамжийн дагуу нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн Агаарын замын боомт хариуцсан газарт 03 дугаар сарын 31-ний өдөр, Дорноговь аймаг дахь газарт 04 дүгээр сарын 08-наас 10-ны өдрийн хооронд томилолтоор ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хэлтсийн дарга, дотоод болон нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн нар 05 дугаар сарын 22, 23-ны өдөр хамрагдаж, 05 дугаар сарын 29-ний өдрийн 2025/2575, 2025/2580, 2025/2569 дугаартай гэрчилгээ авсан.

